



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.5.7, 2.7.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан орос хэлний ярианы гарын авлагын эхийг бэлтгэх, англи хэлний ярианы гарын авлагын эхийг шинэчлэн хэвлүүлэхийг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасгай.


2. Гарын авлагыг бэлтгэх, шинэчлэх, хэвлүүлэх төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх ажилд шаардагдах төсөв 1.800.000 /нэг сая найм зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын
27 өдрийн 106 тоот тушаалын хавсралт



ГАРЫН АВЛАГА БЭЛТГЭХ, ШИНЭЧЛЭХ, ХЭВЛҮҮЛЭХ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Англи хэлний гарын авлагыг шинэчлэх /“Вийзард Лангвиж” ХХК/	1	200.000	200.000
2	Англи хэлний гарын авлагыг хэвлүүлэх /“Содпресс” ХХК/	1000	1100	1.100.000
3	Орос хэлний ярианы гарын авлагын эх бэлтгэх /Монголын зочид буудлуудын холбоо/	1	500.000	500.000
	Нийт төсөв			1.800.000